



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 472

Улаанбаатар хот

### Дархлаажуулалтын үндэсний товлолыг шинэчлэн батлах тухай

Дархлаажуулалтын тухай хуулийн 10.1, 10.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Шинэчлэн батлагдсан үндэсний товлолын дагуу дархлаажуулалтыг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзоригт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Дархлаажуулалтын үндэсний товлолыг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2009 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 185 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЧИНЗОРИГ



Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 472 дугаар ТОГТООЛЫН ХАВСРАЛТ

ЗААВАЛ ХИЙХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН ҮНДЭСНИЙ ТОВЛОЛ

№	Сэргийлэх тарилгын нэр	Эхлэл дархлаажуулалт	Дархлал сэргээх (давтан) дархлаажуулалт
1.	Сүрьеэгийн эсрэг вакцин (БЦЖ)	<ul style="list-style-type: none"> <li>Төрсний дараа 24 цагийн дотор гепатитын В вирусийн эсрэг вакцины нэг дэх тунтай нэгэн зэрэг.</li> </ul>	
2.	Полиомиелит (Хүүхдийн тархи нугасны халдварт саа)-ийн эсрэг уудаг сэргийлэх тарилга	<ul style="list-style-type: none"> <li>Нэг дэх тунг хоёр сартайд нь тавт (сахуу, хөхүүл ханиад, татран, гепатитын В вирус, хемофилюс инфлюэнза В) вакцин, пневмококкийн эсрэг 13 цэнт вакцины нэг дэх тунтай нэгэн зэрэг;</li> <li>Хоёр дахь тунг гурван сартайд нь тавт (сахуу, хөхүүл ханиад, татран, гепатитын В вирус, хемофилюс инфлюэнза В) вакцины хоёр дахь тунтай нэгэн зэрэг;</li> <li>Гурав дахь тунг дөрвөн сартайд нь тавт вакцины (сахуу, хөхүүл ханиад, татран, гепатитын В вирус, хемофилюс инфлюэнза В) гурав дахь тун, пневмококкийн эсрэг 13 цэнт вакцины хоёр дахь тунтай нэгэн зэрэг;</li> </ul>	
3.	Полиомиелит (Хүүхдийн тархи нугасны халдварт саа)-ийн эсрэг тарьдаг сэргийлэх тарилга	<ul style="list-style-type: none"> <li>Дөрөв дэх тунг таван сартайд нь.</li> </ul>	
4.	Гепатитын В вирусийн эсрэг сэргийлэх тарилга	<ul style="list-style-type: none"> <li>Төрсний дараа 24 цагийн дотор сүрьеэгийн эсрэг вакцины нэг дэх тунтай нэгэн зэрэг</li> </ul>	
5.	Улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг сэргийлэх тарилга	<ul style="list-style-type: none"> <li>Нэг дэх тунг есөн сартайд нь пневмококкийн эсрэг 13 цэнт вакцины гурав дахь тунтай нэгэн зэрэг;</li> <li>Хоёр дахь тунг хоёр настайд нь гепатитын А вирусийн эсрэг вакцины хоёр дахь тунтай нэгэн зэрэг;</li> </ul>	

6.	Гепатитын А вирусийн эсрэг сэргийлэх тарилга	<ul style="list-style-type: none"> <li>• Нэг дэх тунг 1 нас 2 сартайд нь;</li> <li>• Хоёр дахь тунг 2 настайд нь улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг вакцины хоёр дахь тунтай нэгэн зэрэг;</li> </ul>	
7.	Пневмококкийн эсрэг 13 цэнт сэргийлэх тарилга	<ul style="list-style-type: none"> <li>• Нэг дэх тунг хоёр сартайд нь тавт (сахуу, хөхүүл ханиад, татран, гепатитийн В вирус, хемофилюс инфлюэнза В) вакцины нэг дэх тун, Полиомиелитийн эсрэг уудаг вакцины нэг дэх тунтай нэгэн зэрэг;</li> <li>• Хоёр дахь тунг дөрвөн сартайд нь тавт (сахуу, хөхүүл ханиад, татран, гепатитийн В вирус, хемофилюс инфлюэнза В) вакцины гурав дахь тун, полиомиелитийн эсрэг уудаг вакцины гурав дахь тунтай нэгэн зэрэг;</li> <li>• Гурав дахь тунг есөн сартайд нь улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг вакцины нэг дэх тунтай нэгэн зэрэг.</li> </ul>	
8.	Сахуу, хөхүүл ханиад, татран, гепатитийн В вирус, хемофилюс инфлюэнза В-ийн эсрэг сэргийлэх тарилга (Тавт вакцин)	<ul style="list-style-type: none"> <li>• Нэг дэх тунг хоёр сартайд нь полиомиелитийн эсрэг уудаг вакцины нэг дэх тун, пневмококкийн эсрэг 13 цэнт вакцины 1 дэх тунтай нэгэн зэрэг;</li> <li>• Хоёр дахь тунг гурван сартайд нь полиомиелитийн эсрэг уудаг вакцины хоёр дахь тунтай нэгэн зэрэг;</li> <li>• Гурав дахь тунг дөрвөн сартайд нь полиомиелитийн эсрэг уудаг вакцины гурав дахь тун, пневмококкийн эсрэг вакцины хоёр дахь тунтай нэгэн зэрэг.</li> </ul>	
9.	Хүний папиллома вирусийн эсрэг сэргийлэх тарилга	<ul style="list-style-type: none"> <li>• Хүүхдийг 11 настайд нь 1 тунгаар хийнэ.</li> </ul>	
10.	Сахуу, татран өвчний эсрэг сэргийлэх тарилга		Нэг дэх тунг долоон насанд хийнэ; Хоёр дахь тунг арван таван насанд хийнэ.

Тайлбар: Вакцины тунгийн хэмжээ, хэрэглэх аргыг тухайн вакцины шинж чанар, үйлдвэрлэгчийн зааврыг үндэслэн Эрүүл мэндийн яам тухай бүр тогтооно.

